



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/594

Улаанбаатар хот

Нислэгийн журам хүчингүй болгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, ИНД-91-Г "Ил харааны нислэгийн журам", ИНД-95 "Хэрэглэлийн нислэгийн дүрмээр буултын ойртолт үйлдэх ба сансрын навигац ашиглах дүрэм", ИНД-91-Д "Хэрэглэлийн нислэгийн дүрэм", ИНД-175.57.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Зам, тээврийн хөгжлийн сайдын "Агаарын зайн ангиллыг шинэчлэн тогтоох тухай" 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тушаал гарсантай холбогдуулан Баянхонгор аймгийн "Баянхонгор" нисэх буудлын А/В болон С ангиллын агаарын хөлөг NDB ашиглан хэрэглэлээр оролт үйлдэх нислэгийн журам, мөн Хэнтий аймгийн "Өндөрхаан" нисэх буудлын А/В болон С ангиллын агаарын хөлөг NDB ашиглан хэрэглэлээр оролт үйлдэх нислэгийн журам, Өвөрхангай аймгийн "Арвайхээр" нисэх буудлын А/В болон С ангиллын агаарын хөлөг чиглүүлэх радио станц ашиглан хэрэглэлээр оролт үйлдэх нислэгийн журмуудыг тус тус хүчингүй болгосугай.

2. Дээрх нислэгийн журмуудыг хүчингүй болгосон талаар зарлан мэдээлэхийг Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба /П.Ариунгэрэл/-нд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, шинэ нислэгийн журмыг дахин зохиох ажлыг хийж гүйцэтгэхийг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газар /Ё.Эрдэнэбат/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/634 дүгээр тушаал, 2012 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/234 дүгээр тушаалын 4,5,21,22 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН